



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: 7010-1388, 7010-1408
E-mail: contact@internalaudit.ub.gov.mn
http://www.internalaudit.ub.gov.mn

2019.07.09 № 02/95
танай _____-ны № _____-г

「НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН」
ТӨВД

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханы баталсан 15 дугаар удирдамжийн дагуу санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлийг хүргүүлж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Я.САРАНСҮХ

1150000150

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн "Түргэн тусламжийн төв" -ийн 2017, 2018 оны
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

Шалгалт хийх үндэслэл: Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны Стандарт батлах тухай 107 дугаар тушаал, нийслэлийн Дотоод аудитын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний, Нийслэлийн Засаг даргын баталсан 2019 оны 15 дугаар удирдамжийн дагуу нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад хийх төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт.

Шалгалтын зорилго: Нийслэлийн "Түргэн тусламжийн төв" -ийн санхүүгийн үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар журамтай хэр нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжлийн арга зүйн зөвлөгөөгөөр хангахад шалгалтын зорилго оршино.

Шалгалтын хамрах хугацаа: 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны санхүүгийн үйл ажиллагаа.

Шалгалт хийсэн хугацаа: 2019 оны 06 дугаар сарын 12 -ны өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл.

Шалгалтын бүрэлдэхүүн:

Багийн ахлагч:

Ахлах мэргэжилтэн /ахлах аудитор/

Д.Нансалмаа /СХШУАБ/

Багийн гишүүн:

Мэргэжилтэн /аудитор/

Б.Ононбайгаль /СХШУБ/

Шалгалтын цар хүрээ:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;

- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт, олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ноогдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал зэргийг хамруулан шалгалаа.

Шалгуулсан аж ахуйн нэгж, объектын байршил:

Нийслэлийн “Түргэн тусламжийн төв” нь Сүхбаатар дүүрэг, Чин Ван Чагдаржавын гудамж өөрийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Шалгалтын явц, шалгалтад хамрагдсан асуудал:

Шалгалтаар тус байгууллагын 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны санхүүгийн тайлан болон санхүүгийн баримтууд нь холбогдох хууль тогтоомж, заавар, журмын заалтад хэр нийцэж байгаа эсэхэд санхүүгийн хяналт шалгалтыг хийж шалгалтаар илэрсэн зөрчлийг багасгах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Үндсэн үйл ажиллагааны талаар:

Нийслэлийн “Түргэн тусламжийн төв” нь анх 1930 оны 10 дугаар сарын 20-нд Ардын эрүүлийг хамгаалах яамны сайдын тушаалаар Улсын клиникийн төв эмнэлгээс тусгаарлан гарч үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Тус байгууллага өдөр, шөнийн 24 цагт байнгын бэлэн байдалд байж, эмнэлгийн яаралтай тусламжийг цаг алдалгүй, үнэ төлбөргүй үзүүлдэг цорын ганц тусгай төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг юм.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дүрэм, бүтэц, үйл

ажиллагааны чиглэлийг батлах тухай” А/26 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар тус байгууллагын дүрмийг баталжээ.

Дүрэмдээ “Нийслэлийн Түргэн тусламжийн төв” нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн иргэдэд цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмслэлт, төрөлтийн үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэх чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага бөгөөд хот суурин газрын хүн амын суурьшил, нягтралаас хамаарч салбартай байна.” гэж заасан байна.

Тус байгууллага дүрэмдээ заасны дагуу захиргаа, автобааз, Баянзүрх салбар, Сонгинохайрхан салбар, Хан-Уул салбаруудад үйл ажиллагаа явуулж иргэдэд үйлчилгээг ойртуулан ажиллаж байна.

Нийслэлийн “Түргэн тусламжийн төв”-ийн автобаазын бүртгэлд 79 тоногосон автомашин бүртгэлтэй байгаагаас тусламж үйлчилгээний байнгын бэлэн байдлыг ханган ажиллах үүднээс өдөрт 40-45 машин бэлэн байдалд дуудлагаар хүрч ажилладаг байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Дд	Ажиллах цаг	Өдөрт гарах автомашины тоо
1	24	25
2	16	16
3	8	4
Нийт		45

Нэг автомашин 24 цагт дунджаар 230-250 км, 30-40 дуудлагад үйлчилдэг байна.

Монгол улсын стандартаар 10000 хүн ам тутамд нэг автомашин үйлчлэх шаардлагатай байна. Иймд нийслэл хотын суурин хүн амын тоонд харьцуулахад 130-140 автомашин байх ёстой буюу нэмж 60-70 автомашины парк шинэчлэлт хийж байж иргэдэд хүрэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх үзүүлэлт харагдаж байна. Бүрэн тоноглолтой автомашины парк шинэчлэлтийг хийснээр өдөрт эмнэлэг үйлчилгээнд ажиллах автомашины тоо нэмэгдэж, иргэдэд үйлчлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанар мэдэгдэхүйц дээшлэх болно. Мөн цаашид салбар төвүүд шинээр ашиглалтад орсноор өдөрт ажиллах автомашины тоо, хүн хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх хэрэгцээ тулгарч байна. Одоогоор эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй автомашинуудын насжилтыг харуулбал :

Дд	Автомашины үйлдвэрлэсэн он	Тоо хэмжээ	Данснаас хасагдах огноо
1	2009	3	2019
2	2011	2	2019
3	2012	4	2019
4	2013	30	2020
5	2014	27	2022
6	2016	10	2024
Нийт		76	

Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь нийслэлийн 6 дүүргийн хүүхэд, насанд хүрэгчдийн дуудлаганд 24 цагаар тасралтгүй үйлчилж байна. Нийслэлийн


хэмжээнд хоногт 900-1200 орчим дуудлага, жилдээ 390 мянга орчим дуудлага иргэдээс хүлээн авдаг байна.

2018 онд нийт том хүний 293884 дуудлага бүртгэгдсэнээс 15253 дуудлага үр дүнгүй дуудлага, хүүхдийн 53252 дуудлага бүртгэгдэж, нийт 331883 иргэнд хүрч үйлчилсэн байна.

Орон тоо, бүтэц зохион байгуулалтын талаар:

Нийслэлийн “Түргэн тусламжийн төв” -ийн захирлын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажил, албан тушаалын жагсаалт батлах тухай” А/03 дугаар тушаалаар 2017 онд ажиллах орон тоо албан тушаалын жагсаалтыг 405 албан хаагчтай байхаар, 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 406 албан хаагчтай байхаар тус тус баталсан байна. Үүнээс гүйцэтгэлээр 2017 онд 397 орон тоотой, 2018 онд 406 орон тоотойгоор ажилласан байна.

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн удирдлага зохион байгуулалт



Тус газар нь регистрийн 9077332 дугаартай төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газрын гэрчилгээтэй, нийслэлийн төрийн сан дахь үндсэн үйл ажиллагааны 100200020006 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100200020406 тоот данснудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Тайлант хугацаанд нэгдүгээр гарын үсгийг нийслэлийн Засаг даргын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 489 дугаар захирамжаар томилогдсон “Түргэн тусламжийн төв”-ийн дарга Ц.Пүрэвдаш, хоёрдугаар гарын үсгийг “Түргэн тусламжийн төв”-ийн даргын 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 36 дугаар тушаалаар томилогдсон ахлах нягтлан бодогч Б.Отгонтэнгэр нар зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, нийслэлийн “Түргэн тусламжийн төв” -ийн дарга Ц.Пүрэвдаштай 2017 он, 2018 онуудад үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг нэмэлтээр тайлагнан ажилласан байна.

Өмнөх шалгалтын талаар:

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Нийслэл дэх төрийн Аудитын газар аудитыг гүйцэтгэж хязгаарлалттай санал дүгнэлт гаргасан байна. “Түргэн тусламжийн төв” -ийн хувьд дараах зөрчлүүд илрүүлсэн байна. Үүнд:

- Бараа материалын тайланд 110.0 мянган төгрөгийн бүрдэл дутуу баримтаар эм тариа зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*” заалтыг зөрчсөн байна.
- Ээлжийн амралттай ажилтанд цалинг давхардуулан 4,986.1 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан ээлжийн амралт олгох зааврын 13. “*Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй.*” заалтыг зөрчсөн байна.
- Төрийн албан хаагч бүрт олгосон 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас 10,300.0 мянган төгрөгийн НДШ-ийг суутгаагүй ЭМЯ -аас санхүүжигдэж төсвөөс олгосон байна.

2018 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд нийслэл дэх төрийн Аудитын газрын захиалгаар “Цэгц төв богд Аудит” ХХК аудитыг гүйцэтгэж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан байна.

Хоёр. Төсвийн гүйцэтгэлийн талаар

2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар:

“Түргэн тусламжийн төв” нь 2018 онд улсын төсвөөс 7,183,169.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 7,076,830.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийг 106,339.4 мянган төгрөгөөр хэмнэн гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.

Зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл: нэмэгдэл цалинг 118,491.3 мянган төгрөгөөр, унаа, болон бусад нөхөн олговрыг 9,930.0 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 24,472.9 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 6,464.7 мянган төгрөгөөр, хог хаягдал зайлуулах, ариутгалын зардлыг 1,796.8 мянган төгрөгөөр, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлыг 0.7 мянган төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 139.7 мянган төгрөгөөр, эд

хогшил худалдан авах зардлыг 216.6 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 780.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 56.6 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 5,992.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Үндсэн цалингийн зардлыг 56,372.9 мянган төгрөгөөр, урамшууллын зардлыг 92.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 1,704.6 мянган төгрөгөөр, шуудан холбоо, интернетийн төлбөрийг 3,833.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн ажилласан байна.

Нийт зардлын 66.0 хувийг цалингийн зардал, 7.8 хувийг нийгмийн даатгалын зардал, 12.2 хувийг тээвэр шатахууны зардал, 2.2 хувийг эм бэлдмэлийн зардал, 11.8 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Зардлын үзүүлэлт	2017 он			2018 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
	Урсгал зардлын дүн	7,183,169.4	7,076,830.0	(106,339.4)	7,409,760.2	7,177,802.3	(231,957.9)
1	Үндсэн цалин	2,706,201.8	2,762,574.7	56,372.9	2,766,574.9	2,730,261.5	(36,313.4)
2	Нэмэгдэл	1,728,833.6	1,610,342.3	(118,491.3)	1,732,689.9	1,614,912.2	(117,777.7)
3	Унаа, болон бусад нөхөн олговор	307,377.1	297,447.1	(9,930.0)	334,308.0	337,001.6	2,693.6
4	Урамшуулал	271,599.8	271,691.8	92.0	276,560.9	276,568.9	8.0
5	Нийгмийн даатгалын шимтгэл	551,541.3	551,541.3	-	613,216.1	592,050.3	(21,165.8)
6	Ашиглалтын зардал	162,303.3	137,830.4	(24,472.9)	185,546.5	130,544.5	(55,002.0)
7	Бичиг хэрэг	2,210.6	3,915.2	1,704.6	3,710.6	3,709.8	(0.8)
8	Тээвэр (шатахуун)	868,045.6	861,580.9	(6,464.7)	933,061.4	933,061.3	(0.1)
9	Шуудан холбоо, интернет төлбөр	12,023.7	15,857.2	3,833.5	16,523.7	16,586.1	62.4
10	Хог хаягдал зайлуулах, ариутгалын	57,125.5	55,328.7	(1,796.8)	77,746.5	77,812.5	66.0
11	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	5,359.7	5,359.7	-	11,256.4	8,610.4	(2,646.0)
12	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	158,952.7	158,952.0	(0.7)	183,268.4	183,253.8	(14.6)
13	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,398.2	16,258.5	(139.7)	24,382.0	24,382.0	-
14	Эд хогшил худалдан авах	38,261.3	38,044.7	(216.6)	96,687.6	96,686.7	(0.9)
15	Томилолт, зочны зардал	4,683.8	3,903.0	(780.8)	4,683.8	4,683.8	-
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	148,140.4	148,083.8	(56.6)	149,543.5	147,676.9	(1,866.6)
17	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	144,111.0	138,118.7	(5,992.3)			-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	7,183,169.4	7,076,830.0	(106,339.4)	7,409,760.2	7,177,802.3	(231,957.9)
1	Улсын төсвөөс	7,183,169.4	7,076,830.0	(106,339.4)	7,409,760.2	7,177,802.3	(231,957.9)

2018 онд улсын төсвөөс 7,409,760.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 7,177,802.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийг 231,957.9 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл: үндсэн цалингийн зардлыг 36,313.4 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 117,777.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 21,165.8 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 55,002.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 0.8 мянган төгрөгөөр, тээвэр

шатахууны зардлыг 0.1 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг 2,646.0 мянган төгрөгөөр, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлыг 14.6 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 0.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,866.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Унаа, болон бусад нөхөн олговрыг 2,693.6 мянган төгрөгөөр, урамшууллын зардлыг 8.0 мянган төгрөгөөр, шуудан холбоо, интернетийн зардлыг 62.4 мянган төгрөгөөр, хог хаягдал зайлуулах, ариутгалын зардлыг 66.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн ажилласан байна.

Нийт зардлын 65.2 хувийг цалингийн зардал, 8.2 хувийг нийгмийн даатгалын зардал, 13.0 хувийг тээвэр шатахууны зардал, 2.5 хувийг эм бэлдмэлийн зардал, 11.1 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

2.2 Санхүүгийн тайлангийн талаар

"Түргэн тусламжийн төв" нь 2017 оны санхүүгийн тайланг 487,985.9 мянган төгрөгийн эргэлтийн 4,467,202.4 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 4,955,188.3 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

		Санхүүгийн тайлан /мянган төгрөгөөр/		
Д/д	Балансын зүйл	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Авлага	16,759.4	13,896.3	14,704.4
2	Бараа материал	439,486.8	474,089.6	540,766.2
	Эргэлтийн хөрөнгийн дүн	456,246.2	487,985.9	555,470.6
3	Биет хөрөнгө	5,532,543.0	4,465,222.4	7,351,935.2
4	Биет бус хөрөнгө	12.5	1,980.0	508,259.2
	Үндсэн хөрөнгийн дүн	5,532,555.5	4,467,202.4	7,860,194.4
	Нийт хөрөнгийн дүн	5,988,801.7	4,955,188.3	8,415,665.0
5	Өглөг	1,666.9	-	-
	Өр төлбөрийн дүн	1,666.9	-	-
6	Төрийн өмч	3,804,210.9	3,804,210.9	4,269,530.2
7	Хуримтлагдсан үр дүн	1,141,936.3	110,666.6	872,204.9
8	Дахин үнэлгээний зөрүү	1,040,987.6	1,040,310.8	3,273,929.9
	Эздийн өмчийн дүн	5,987,134.8	4,955,188.3	8,415,665.0
	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	5,988,801.7	4,955,188.3	8,415,665.0

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланд 555,470.6 мянган төгрөгийн эргэлтийн 7,860,194.4 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 8,415,665.0 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

2.3 Мөнгөн хөрөнгийн талаар

2017 онд харилцах дансаар 7,315,286.5 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансаар 9,800.0 мянган төгрөгийн, кассаар 6,794.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсан байна.

2018 онд харилцах дансаар 7,542,443.7 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансаар 27,292.0 мянган төгрөгийн, кассаар 7,716.3 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлж зарцуулсан байна.

Хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Д/д	Мөнгөн хөрөнгө	Банк, дансны дугаар	2017 он		2018 он	
			Мөнгөн орлого	Мөнгөн зардал	Мөнгөн орлого	Мөнгөн зардал
1	Касс		6,794.6	6,794.6	7,716.3	7,716.3
3	Харилцах	100200020007	7,315,286.5	7,315,286.5	7,542,443.7	7,542,443.7
4	Нэмэлт данс	100200020407	9,800.0	9,800.0	27,292.0	27,292.0
Нийт			7,331,881.1	7,331,881.1	7,577,452.0	7,577,452.0

2.4 Авлагын талаар

2017 он 13,896.3 мянган төгрөгийн, 2018 онд 14,704.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тайлагнасан байна.

2017, 2018 оны авлаг

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2017 он			2018 он			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Ажилчидтай холбоотой	-	1,677.3	1,541.8	135.5	14,128.2	12,694.1	1,569.7
2	Цахилгааны авлага	-	1,164.8	1,164.8	-	-	-	-
3	Тээвэр шатахууны тооцоо	-	4,169.5	4,169.5	-	-	-	-
4	Сэлбэг шатахууны тооцоо	5,125.7	4,783.9	6,148.9	3,760.7	631.6	1,257.5	3,134.7
5	Бусад зардлын тооцоон	288.7	-	288.7	-	-	-	-
6	Хувь хүнээс авах авлага	11,345.0	-	1,345.0	10,000.0	-	-	10,000.0
Нийт дүн		16,759.4	11,795.5	14,658.7	13,896.3	14,759.8	13,951.6	14,704.4

Хувь хүнээс авах авлага нь тус төвийн эзэмшилд байсан Вольсваген машинд 2004 онд суурьлуулсан 10,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий цахилгаан бичлэгийн аппарат, дефибрилятор хүчил төрөгчийн иж бүрдэл холбогдох эзэнгүй болсонтой холбоотойгоор үүссэн авлага байна.

Энэхүү авлагатай холбоотойгоор шүүхийн байгууллагад хандсан боловч 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 3633 дугаар "Иргэний хэрэг үүсгэсэн захирамжийг хүчингүй болгож, нэхэмжлэхийг хүлээн авахаас татгалзсан тухай" захирамж ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," заалтыг зөрчин тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй тооцоог данс бүртгэлд тусгасан байна. Мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.5. Бараа материалын талаар

"Түргэн тусламжийн төв" нь 2017 онд 1,121,932.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,087,330.1 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдаж, 474,089.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна. Мөн 17,175.9 мянган төгрөгийн эм боох материал, 51,144.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 7,709.6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, нийт 76,030.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр	2017 оны 12 сарын 31-ний байдлаар				2018 оны 12 сарын 31-ний байдлаар		
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэргийн материал	2,191.5	15,961.2	14,853.7	3,299.1	15,952.0	15,569.0	3,682.1
2	Аж ахуйн материал	263,605.9	86,150.8	99,195.2	250,561.5	118,714.0	92,171.5	277,104.0
3	Сэлбэг хэрэгсэл	46,691.9	212,663.1	193,704.0	65,651.0	226,078.9	241,050.5	50,679.4
4	Түлш шатах тослох матер	16,983.5	645,899.4	636,681.0	26,201.8	706,009.8	697,748.8	34,462.9
5	Эм боох материал	110,014.0	161,258.4	142,896.2	128,376.2	193,321.7	146,860.1	174,837.8
	Нийт	439,486.8	1,121,932.9	1,087,330.1	474,089.6	1,260,076.5	1,193,399.9	540,766.2

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,260,076.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,193,399.9 мянган төгрөгийн бараа материалын зарлага гаргаж, 267,658.1 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

6,732.6 мянган төгрөгийн эм боох материал, 17,912.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 9,014.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, нийт 33,660.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг сонгон шалгаруулж байгаа хэдий ч тендер хугацаа алдаж зарлагдаж байгаагаас шалтгаалж, тендер зарлах хүртэл 2017 онд 10,304.6 мянган төгрөгийн, 2018 онд 10,896.3 мянган төгрөгийн нийт 21,200.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тендергүй шууд гэрээгээр худалдан авсан зөрчил байна.

2.6. Үндсэн хөрөнгийн талаар

Тус байгууллага нь 2017 онд 3,685,234.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 4,690,751.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2,045,665.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 132,796.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 128,592.1 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 2,295.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 10,685,335.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байснаас 320,215.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 368,927.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаж, нийт 6,169,421.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж 4,467,202.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тайлагнажээ.

НЗД-ын 2017 оны 05 дугаар сарын 17 ны өдрийн А/311 дугаар захирамж, НӨХГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 19 ны 2/640 дугаар албан бичгээр нэг бүр нь 30,000.0 мянган төгрөгийн Киа Керата машин 2 ширхэг, 229,445.0 мянган төгрөгийн 4 ширхэг старекс тээврийн хэрэгсэл нийт 289,455.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нэмэгдсэн байна. НӨХГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 10 ны өдрийн 2/472 дугаар зөвшөөрлөөр 2,345.0 мянган төгрөгийн, НӨХГ-ын 2017 оны 07 дугаар сарын 21 –ний өдрийн 2/1002 дугаар зөвшөөрлөөр 1,019.0 мянган төгрөгийн, НӨХГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 10 –ны өдрийн 2/472 дугаар зөвшөөрлөөр 10,621.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, НӨХГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 10 -ны өдрийн 2/472 дугаар зөвшөөрлөөр 5,235.2 мянган төгрөгийн,

НӨХГ-ын 2017 оны 07 дугаар сарын 21 -ний өдрийн 2/1002 дугаар зөвшөөрлөөр 4,269.8 мянган төгрөгийн, НӨХГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 10 ны 2/1793 дугаар зөвшөөрлөөр 3,990.8 мянган төгрөгийн нийт 13,495.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,300.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,980.0 мянган төгрөгийн програм хангамж тус тус нэмэгдсэн байна.

НӨХГ-ын 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 2/658, 2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 4/719, 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 4/777, 2017 оны 05 дугаар сарын 26 -ны 4/709, 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 4/778 дугаар зөвшөөрлүүдээр нэг бүр нь 37,950.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 189,750.0 мянган төгрөгийн старекс машин, НӨХГ-ын 2017 оны 10 дугаар сарын 03 -ны өдрийн А/487 дугаар зөвшөөрлөөр 179,177.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж тус тус акталж устгасан байна. Хүснэгтээр харуулбал:

2017 оны үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Барилга байгууламж	3,685,234.7	0.0	0.0	1,640,261.2	2,044,973.5
2	Тээврийн хэрэгсэл	4,690,751.5	289,455.0	189,750.0	3,020,038.1	1,770,418.4
3	Машин тоног төхөөрөмж	2,045,665.6	13,495.8	171,609.0	1,297,824.3	589,728.1
4	Тавилга, эд хогшил	132,796.3	13,985.0	7,568.1	87,589.1	51,624.1
6	Бусад үндсэн хөрөнгө	128,592.1	1,300.0	0.0	121,413.7	8,478.3
7	Программ хангамж	2,295.0	1,980.0	0.0	2,295.0	1,980.0
	Нийт дүн	10,685,335.2	320,215.8	368,927.2	6,169,421.4	4,467,202.4

2018 онд НЗД-ын 2018 оны 01 дүгээр сарыг 31 -ний өдрийн А/88 дугаар захирамж, НЭМГ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 18 -ны өдрийн А/143 дугаар тушаалын дагуу 2,681,781.1 мянган төгрөгийн өртөг бүхий Хан-Уул салбарын барилга байгууламжийг хүлээн авсан байна. Мөн барилга байгууламж дахин үнэлгээгээр 2,568,267.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 3,159,112.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

НӨХГ-ын 2018 оны 03 дугаар 23-ны өдрийн 3/451, 2018 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн А/798 дугаар зөвшөөрлөөр 37,950.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 4 ширхэг Старекс машиныг данс бүртгэлээс хассан байна.

НӨХГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 3/956 дугаар албан бичиг, тендер шалгаруулалтаар нийт 41,176.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, НЗДТГ, ДЗОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн бэлэглэлийн гэрээгээр, НЭМГ-ын даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/163 дугаар бичгээр үнэ төлбөргүй 5,227.3 мянган төгрөгийн майхан, НЗД-ын 2018 оны 01 дүгээр сарын 31 -ний өдрийн А/88 дугаар захирамж, НЭМГ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 18 -ны өдрийн А/143 дугаар тушаалаар 75,000.0 мянган төгрөгийн, НӨХГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 25 -ны өдрийн 3/956 дугаар албан бичиг, тендер шалгаруулалтаар 39,050.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж тус тус нэмэгдсэн байна.

Хандив тусламжаар 42,157.5 мянган төгрөгийн GPS биет бус хөрөнгөнд бүртгэж авсан байна.

Мөн Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалын дагуу байгууллагын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн байна. Дахин үнэлгээтэй холбоотойгоор бусад биет бус хөрөнгөнд 465,319.3 мянган төгрөгийн салбаруудын газар эзэмших эрхийг бүртгэгдсэн байна.

2018 оны үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Байгуулсан элэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	3,685,234.7	5,250,048.8	3,159,112.5	0.0	5,776,170.9
2	Тээврийн хэрэгсэл	4,790,456.5	0.0	151,800.0	3,552,082.2	1,086,574.4
3	Машин тоног төхөөрөмж	1,887,552.4	132,429.5	0.0	1,617,024.1	402,957.8
4	Тавилга, эд хогшил	139,213.2	46,403.3	0.0	99,384.3	86,232.1
5	Бусад үндсэн хөрөнгө /Нийтийн эзэмшил/	129,892.1	0.0	129,892.1	0.0	0.0
6	Программ хангамж	4,275.0	42,157.5	0.0	3,492.6	42,939.9
7	Бусад биет бус хөрөнгө	0.0	465,319.3	0.0	0.0	465,319.3
Нийт дүн		10,636,623.8	5,936,358.4	3,440,804.6	5,271,983.2	7,860,194.4

Нийслэлийн Засаг даргын 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох тухай" 326 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийслэлийн Яаралтай түргэн тусламжийн төвийн автобаазын шатахуун түгээх станцыг шинэчлэх хөрөнгө оруулалтын ажлыг зохих журмын дагуу хийхийг "Сод Монгол Групп" ХХК-д зөвшөөрсүгэй" гэсэн захирамж гарсан байна.

Дээрх захирамжийн дагуу нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Ганбаатар, "Сод монгол групп" ХХК-ийн хооронд байгуулсан 2008 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн "Барилгад их засвар хөрөнгө оруулалт хийлгэх тухай байгуулсан гэрээ" 04 дүгээр гэрээ байгуулсан байна. Гэрээний 3.7 "хөрөнгө оруулалтын ажил дуусч барилга ашиглалтанд орсон өдрөөс эхлэн түрээсийн төлбөр төлж эхлэнэ." заалтыг зөрчиж одоог хүртэл тус байгууллагаас түрээсийн төлбөрийг аваагүй байна.

Мөн тус шатахуун түгээх станц нь гадна талбай 1128 м кв газрын, 11.2 м кв ерөөний түрээсийн төлбөрийг төлдөггүй зөвхөн ашиглалттай холбоотой цахилгааны төлбөрийг тоолуурын заалтгүйгээр төлдөг байна.

2.7 Нэмэлт санхүүжилтийн талаар

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2017 онд нийслэлийн Эрүүл мэндийн газраас марафон гүйлттэй холбоотой 1,000.0 мянган төгрөгийн, баяр наадамын үйл ажиллагаатай холбоотой 3,500.0 мянган төгрөг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас 5,300.0 мянган төгрөгийн санхүүжилт нийт 9,800.0 мянган төгрөгийн орлого төвлөрч 9,800.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2018 онд нийслэлийн Эрүүл мэндийн газраас марафон гүйлттэй холбоотой 1,000.0 мянган төгрөгийн, баяр наадмын үйл ажиллагаатай холбоотой 8,100.0

мянган төгрөгийн, Нүүдэлчин наадамтай холбоотой 3,192.0 мянган төгрөгийн, нийслэлийн Засаг даргын шагнал урамшууллын 15,000.0 мянган төгрөгийн нийт 27,292.0 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

2.8 Худалдан авах ажиллагааны талаар

Тус байгууллага 2017 онд "Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ" нээлттэй тендер шалгалруулалтыг 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан байна. Тус тендерт "Бүрэн дуулга" ХХК шалгарч 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 69,850.0 мянган төгрөгийн 2017/01 дугаарт гэрээг байгуулсан байна.

2018 онд "Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ" нээлттэй тендер шалгаруулалтыг 2018 оны 04 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан байна. Тус тендерт "Бүрэн дуулга" ХХК шалгарч 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 49,500.0 мянган төгрөгийн 2018/0401 дугаарт гэрээг байгуулсан байна.

Тавилга техник хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч амжилтгүй болсон тул шууд гэрээг байгуулан ажилласан байна. 2018/1001 дугаарт 79,986.0 мянган төгрөгийн гэрээг "Мед буян" ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна.

Гурав. Санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны талаар:

"Түргэн тусламжийн төв"-ын санхүүгийн үйл ажиллагаа нь ахлах нягтлан бодогч 1, тооцооны нягтлан бодогч -4, нярав -3 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Эдгээр нь Санхүүгийн тооцоолох ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн Acolous, Payroll цалингийн програмуудыг ашиглан нягтлан бодох бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлангаа бэлтгэдэг байна.

Шалгалтын явцад санхүүгийн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Ололттой тал: Тус байгууллага үнэлгээгээр 2017 он, 2018 онуудад "А" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2017 он, 2018 оны санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг харьяалагдах байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан байна.

Мөн төсвийг 2017 онд 106,339.4 мянган төгрөгөөр, 2018 онд 231,957.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

2017 он, 2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

- Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг сонгон шалгаруулж байгаа хэдий ч тендер хугацаа алдаж зарлагдаж байгаагаас шалтгаалж, тендер зарлах хүртэл 2017 онд 10,304.6 мянган төгрөгийн, 2018 онд 10,896.3 мянган төгрөгийн нийт 21,200.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тендергүй шууд гэрээгээр худалдан авсан зөрчил байна.
- Өмчийн харилцааны газрын дарга М.Ганбаатар, "Сод монгол групп" ХХК-ийн хооронд байгуулсан 2008 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн "Барилгад их засвар хөрөнгө оруулалт хийлгэх тухай байгуулсан гэрээ" 04 дүгээр гэрээ байгуулсан байна. Гэрээний 3.7 "хөрөнгө оруулалтын ажил дуусч барилга ашиглалтанд орсон өдрөөс эхлэн түрээсийн төлбөр төлж эхлэнэ." заалтыг зөрчиж одоог хүртэл тус байгууллагаас түрээсийн төлбөрийг аваагүй.
Мөн тус шатахуун түгээх станц нь гадна талбай 1128 м кв газрын, 11.2 м кв өрөөний түрээсийн төлбөрийг төлдөггүй зөвхөн ашиглалттай холбоотой цахилгааны төлбөрийг тоолуурын заалтгүйгээр төлдөг.
- Насжилт өндөртэй авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй тайлант хугацаанд шүүхэд хандаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна.
- Автомашиний сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа тендер шалгаруулалт явуулаагүй 51,500.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1"... техникийн саналын шаардлага хангасан ба 3 ба түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ

"Нийслэлийн Түргэн тусламжийн төв"-ийн дарга 2017 он, 2018 онуудад үр дүнгийн гэрээний үүргийг амжилттай хэрэгжүүлж ажилласан байна.

Тус төвийн удирдлага, санхүүгийн ажилтнууд санхүү, нийгмийн даатгалын тайланг батлагдсан маягтаар цаг хугацаанд нь гаргаж зохих байгууллагуудаар баталгаажуулсан байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж байна.

Цаашид анхаарч ажиллах талаар:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан заавар журмуудыг мөрдлөг болгон ажиллах,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1"... техникийн саналын шаардлага хангасан ба 3 ба түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" заалтыг мөрдөж ажиллах,
- Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж, зарцуулах", 16.5.5, "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтуудыг мөрдөж ажиллах,
- Олон жилийн насжилттай, хөөн хэлэлцэх хугацаа дууссан авлагыг шүүхийн байгууллагад хандан 2019 оны 04 дүгээр улиралд багтаан шийдвэрлүүлэх,
- "Сод Монгол Групп" -тэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хандаж асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэх.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ  Ч.ГҮРБАЗАР

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Д.НАНСАЛМАА

АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Б.ОНОНБАЙГАЛЬ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

"НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ" -ИЙН
ЗАХИРАЛ  Ц.ПҮРЭВДАШ

АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧ  Б.ОТГОНТЭНГЭР